

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сандалын Нямжав	Дугаар	L215
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Цагаанхайрхан сум
Төрсөн газар	Цагаанхайрхан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан / эмч, домч /		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цахиуртын хүрээ	Сүм хийдийн дугаар	УВЦХ 016
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 13	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх



Увс аймгийн Цагаанхайрхан сумын Цахиуртын хүрээ

Нямжав: Манай авга ах, миний ээжийн нагац ах манай авга ах нар энэ Ханхөхий хошууны эмч нар байсан юм аа, дээр үед лам нар.Тэгээд ургамлаар хүнийг их эмчилдэг эмч нар байсан юм. Тэгээд энэ Ховд Улиастайгаас улсууд ирж эмнүүлж , хүнд өвчтэй улсууд ирж эмнүүлж байсан юм гэнэ лээ, тэрнийг би сайн мэддэггүй юм. Намайг 5 настай байхад миний даавуун уутаар дүүрэн цэцэг түүж сургасан юм. Тэгээд би яахав тэр хоёрт цэцэг түүж өгч байж байгаад би найман нас хүрсэн л дээ. Найман нас хүрээд, манай ээжийн нагац ах чинь 98-тай өнгөрсөн.Тэгээд миний авга намайг естэй, арав хүрдэг жил өнгөрсөн.Тэгээд тэрнээс хойш за энэ хөгшчүүл чинь ингээд болохоо байдаг юм шүү, миний хүү наад цэцэг ургамлаа битгий хамаагүй хүнд яагаарай гэж үлдээсэн, захисан.Тэгээд би нууцаар яваад л өгдөг байсан, тэгээд хэлдэг ч үгүй, намайг амьтан тоодог ч үгүй. Би нэг малд хөөцөлдөөд л нэг л тийм хүн явлаа л даа, хэдэн хөгшчүүлийн дунд. Тэгж явж байгаад л тавин хоёр онд малаа

**Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 1 хувийн мэдээллээс бүрдсэн болно.**

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нийгэмчлээд л тэгээд л нэгдлийн гишүүн болоод л ингээд л амьдарч явж байгаад л далан, жаран дөрвөн онд миний таньдаг нэг найз элэгний өвчтэй, их мүүдаад. Хот яваад эмчилгээнд,онгоцоор долоон хоногийн дотор харицгаа гаргаж байгаад хүрээд ирсэн байсан. Тэгээд тэрнийг би эхлээд эмчилсэн.Тэр гучин наймтай хүн байсан. Тэгээд тэрнийг би нэг хоёр сар эмчлээд л байж байгаад л . Тэгээд л тэр хүн болоод л , б1 хүртлээ тэр ямар ч өвчингүй явж байгаад л насны эрхэнд явсан юм байлгүй, тэгээд л өнгөрсөн.Тэгээд олон түмэнд яахав өөрийнхөө мэдэх нэг хэдэн цэцгээр ингээд туслаад явж байдаг юм.Тэгээд уг нь боломжтой бол би нэг орон гэр бариад тэр өвчтэй улсуудыг авчраад гараараа эмчилвэл сайн байдаг юм. Тэгээд гэр оронд нь очоод эмчлэхээр заавал нэг алдагдал гаргачихаад байгаа юм, өөрснөө болохлээр. Тэгээд би одоо наяд хүрэх гэж явна, хичнээн жил ч эмчлэх юм.Нэг хоёр залуу байтугай, хоёр гурван эмэгтэй өлгийднө. Тэгээд олон жил яадах юм уу, үгүй юм уу мэдэхгүй.Тэгээд тэр манай энэ хөгшчүүл нь Цахиуртайн хүрээ гэдэг байсан.Тэгээд тэрүүнд эм хийж байсан, нэг нь бас улсад багшилж байсан хүн шиг байна лээ, тэр Ааяа гэдэг нь. Наад Лхамсүрэн нь ч яахав, тэр эм талын юмыг л барьдаг байсан. Тэгээд энд нэг хэдэн жижиг байшин, жаахан байлаа, би. Хэдэн жижиг байшин байж л байлаа.Учрыг нь ч мэддэггүй байлаа. Зоч лүйжин тавьж байна энэ тэр гээд, булаг жасанд явж л байна гэж бас эрэгтэй хүүхэдтэй ярьдаг л байсан.Тэгээд л ирчихээд л багш нар нь аль нь ч байсан юм ,учрыг нь сайн олдоггүй, шалгалт өгч байгаа юм уу гээд л . Шөнө болохлээр ном уншаад л , хонх дамар дуугаргаад л ингээд л байдаг байсан.Тэгээд тэр улсуудын үйлчилгээ ер нь өвчтэй зовлонтой улсуудад л үйлчилдэг байсан бололтой юм шиг байна лээ.Тэгээд яахав нэг хүн амьтан хээр хоночихоод арай үхээгүй шиг байхад очихлээрээ нэг босгочихдог. Малаар нэг гэр гадаа оторт төөрчихсөн үхэр мал үхэх гээд хэвтэж байхад нь босгочихдог. Тийм л талаар номтой улс байсан юм уу гэж би ингэж ойлгодог юм, одоо.Тэгээд хамгийн сүүлд манай нэг хөгшин байж байгаад, өвчтэй хэвтэрт байж байгаад сая өнгөрчихсөн юм. Тэрүүнийг би сайн мэдэж байгаа нь тэр их салхи шуургатай жил адуу мал, тэмээ мал хурааж яваад адуу мал тууж яваад, адуу мал эрх алдаад уначихсан байж байхад хоноод адуу унасан мал амьд байж байвал тэр хөгшин давхиж хүрээд л , тэр хөгшин нэг шороо юм уу, ус л өгдөг. Энийг аваачаад цацчих. Тэгээд л тэрнийг аваачаад л цацачихаар хоносон адуу, нэг хоноод юм уу босоод зүгээр хамаагүй явчихдаг.Тэмээ болвол зүгээр мөн босоод хаашаа ч хамаагүй гүйдэг.Тийм хөгшин байж байгаад саяхан өнгөрлөө л дөө. Надад ч тийм чадал алга зүгээр, гэхдээ би яахав зүгээр нэг ойр зуурын юмыг засаж сэлгэх санаа л байдаг юм. Өвчний талын юм, биенд тулсан өвчний талын юмыг л би нааш, цааш нь болгодог. Яахав надад нэг их ч юм байдаггүй юм аа, би нэг элэгний талын юм, бөөр нурууны талын юм цэцгээ олоод авбал. Аа тэгээд ходоодны нэг шарх, сорив тийм юмын талын юм л жаахан цэцэг олж туслая гэж боддог хүн.Одоо наяд хүрэх гэж явна, би одоо тэгээд хичнээн ч жил тусална гэж дээ.Тэгээд л гүйцэх байлгүй дээ.

Билэг-Өрнөх: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 2  
хувийн мэдээллээс бүрдсэн болно.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3